

Төв аймгийн Статистикийн хэлтэс

..... танаа



Төвийн бүсийн эдийн засаг нийгмийн хөгжил
2011 оны судалгаа
танилцуулга

Зуунмод

2012 он

Гарчиг

- I. Өмнөх үг.**
- II. Товч танилцуулга**
- III. Улсын хэмжээний нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эзлэх зиндаа**
- IV. Засаг захиргааны нэгж, Төвийн бүсийн аймгуудын Дотоодын нийт бүтээгдэхүүн**
- V. Хүн ам**
 - V.1. Суурин хүн ам, Өрхийн тоо.
 - V.2. Бүтэн, Хагас өнчин хүүхдийн тоо.
 - V.3. 16 хүртлэх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй болон,Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо
 - V.4. 16 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүд, Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо.
 - V.5. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт.
 - V.6. Төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалт,үрчлэлт болон хүн амын дундаж наслалт
 - V.7. Эдийн засгийн идэвхитэй хүн ам, Ажиллагчдын тоо.
 - V.8. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, Ажилгүйдлийн түвшин.
- VI. Малын тоо, бүтэц**
 - VI.1. Нийт малын болон Тэмээний тоо.
 - VI.2. Адуу,Үхрийн тоо.
 - VI.3. Хонь, Ямааны тоо.
- VII. Газар тариалан**
 - VII.1. Тариалсан талбай, Хураан авсан үр тариа.
 - VII.2. Хураан авсан Төмс, Хүнсний ногоо.
- VIII. Төсөв**
 - VIII.1. Орон нутгийн төсвийн орлого, Зарлага.
 - VIII.2. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого.
- IX. Аж үйлдвэр,Барилга**
 - IX.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт, Гадаад дотоодын хамтарсан барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт,их засварын ажил.
- X. Боловсрол,Соёл,Эрүүл мэнд**
 - X.1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ЕБС-д өдрөөр суралцагсад.
 - X.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын тоо,ЕБС-ийн нэг багшид ногдох суралцагчид
 - X.3. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт, үзэгчид.
 - X.4. Музейн үзвэр, үзэгчид, Сүм хийдийн тоо.
 - X.5. Их эмчийн болон нэг их эмчид ногдох хүний тоо.
 - X.6. Нэг сувилагчид ногдох хүн, Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо.
 - X.7. Үр хөндөлт, Халдварт өвчнөөр өвчлөөд бүртгэгдсэн хүмүүс.
 - X.8. 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох Нялхсын эндэгдэл, Төрөхийн улмаас эндсэн эхийн Тоо
- XI. Гэмт хэрэг**
 - XI.1. Бүртгэгдсэн гэмт хэргийн болон Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо
- XII. Графикууд**

Өмнөх үг

2011 оны жилийн эцсийн байдлаар төвийн бүст багтдаг аймгууд улсын хэмжээний газар нутгийн 30,26%, засаг захиргааны (нийт сумдын) нэгжийн 28.11%, нийт хүн амын 16.22%, Өрхийн 18.04 %, эдийн засгийн идэвхитэй хүн амын 19.04%, нийт ажиллагсадын 19.22%, нийт малын 23.25%, үүний дотор тэмээний 50.75%, адууны 23.54%, үхрийн 19.25%, хонины 23.02%, ямааны 23.55%, тариалсан талбайн 72.22 хувь, хураан авсан үр тарианы 77.02 хувь, төмсний 67.80 хувь, хүнсний ногооны 62.32 хувь нь ногдож, Дотоодын нийт бүтээгдэхүүний 10.71 орчим хувийг үйлдвэрлэж, орон нутгийн төсвийн орлогын 28.29 хувийг, зарлагын 29.64 хувь нь ногдож, Улсын хэмжээний Ерөнхий боловсролын сургуулийн 20.74 %, тэнд суралцагсадын 16.54 %, ЕБС-ийн өмнөх байгууллагын 20.36 хувь ногдлоо.

1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас 0.4 промиллоор бага, хүн амын дундаж наслалт улсын дунджаас (Дархан, Дорноговиос бусад нь)дээгүүр (0.12-3.09 насаар) гарав.

Энэ бүсийн дүнгээр амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл улсын дунджаас 63.4 хувиар буюу 6.4 хүүхдээр бага байна.

Ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 0,9 хувиар бага, нэг их эмчид ногдох хүний тоо улсын дунджаас 113 хүнээр, нэг сувилагчид ногдох хүн 45-аар тус тус их байгаа нь эмнэлэгийн боловсон хүчний хангалт доогуур байгаатай холбоотой.

х . х . х

Төвийн бүс нутагтаа манай аймаг сум, багийн тоогоор 1-т, газар нутгийн хэмжээгээр 4-т, хүн амын тоогоор 3-т, малын тоогоор 1-т, газар тариалангийн үйлдвэрлэлээрээ 2-т, Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр 4-т, хүн амын дундаж наслалтаараа 3-т, эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагсадын тоогоороо 2-т, ХХҮХ-т бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоогоороо 5-т, орон нутгийн орлого бүрдүүлэлт зарлага хэрэглээгээр тус тус 5-т, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаараа 5-д, барилга угсралт, их засварын ажлаар 2-т, Ерөнхий боловсролын сургуулийн тоогоор 2-т, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоогоороо 1-д байгаа бол, Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоогоор 3-т, цэцэрлэгийн хүүхдийн тоогоор 2-т, нэг их эмчид ногдох хүний тоогоор 2-т, нэг сувилагчид ногдох хүний тоогоор 3-д орж байна.

1000 хүнд ногдох нялхсын эндэгдлийн тоогоор бүсдээ 3-т, бүртгэгдсэн гэмт хэргийн тоогоор 1-т, шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоогоор 3-т оров.

Тайлбар: Энэ зэрэгцүүлэлт судалгааг ҮСХ-ноос гаргадаг Монгол улсын статистикийн 2005-2010 оны эмхтгэл болон жил бүрийн бюллетень танилцуулгуудыг ашиглав.

Статистикийн хэлтсийн

дарга

Ж.Отгончулуун.

Товч танилцуулга

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт

Төвийн бүсийн аймгуудын хүн ам 2011 оны жилийн эцсийн байдлаар 456.1 мянгад хүрч өмнөх оноос 1.20 хувиар, үүнээс дотор Төв аймгийн хүн ам 300 хүн буюу 0.4 хувиар өслөө.

Төвийн бүсийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн амын 56.5 хувь нь хөдөөд амьдарч байгаагийн дотор Төв /80.3%/, Дундговь /77.1%/, Сэлэнгэ /70.4%/, Өмнөговь /64.0%/ аймгийн талаас илүү хувь нь хөдөөд оршин сууж байна. Монгол улсын нийт өрхийн 18.04 хувь нь төвийн бүсэд амьдарч байна.

Бүсийн хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2011 онд 6445 болж нийт хүн амын 1.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 2005 оноос 26.9%, 2010 оноос 2.8%-аар буурсан бол Төв аймгийн хэмжээнд бүтэн өнчин 127, хагас өнчин 1063 хүүхэд байгаа нь өмнөх оноос бүтэн өнчин 16, хагас өнчин 192 хүүхдээр буурчээ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд 2011 онд 17226 байгаагийн 24% нь Дархан, 16% нь Төв, 15.7% нь Сэлэнгэ, 15.5% нь Өмнөговь, 14% нь Дорноговь, 11% нь Дундговь, 3.8% нь Говьсүмбэр аймагт амьдарч байна. 16 хүртлэх насны хүүхэдтэй, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 7890 болж 2008 оныхоос 17.6 хувиар, 2009 оныхоос 11.6 хувиар, 2010 оныхоос 2.08 хувиар буурлаа. Төв аймагт эдгээр эмэгтэйчүүдийн 14.88 хувь нь амьдарч байгаа ба 2010 оноос 0.56 пунктээр буурчээ. Бүсийн хэмжээнд 16 хүртлэх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2011 онд 2607 болж нийт өрхийн 1.9 хувийг эзэлж байгаа нь улсын дүнгээс 1.3 пунктээр бага байна.

Төрөлтийн түвшин 2006-2009 онд нэмэгдэж, 1000 хүнд ногдох төрөлт 2009 онд 26.3 хүрч байснаа 2010 онд 22.9 болж буурсан. 2011 онд 24.7 болж, өмнөх оныхоос 1.8 промилоор өслөө. Нийт 11188 хүүхэд, үүний 5456 нь эмэгтэй, 5732 нь эрэгтэй хүүхэд төрж төрөх үеийн хүйсийн харьцаа 105.1 болов.

Хүн амын нас баралтын түвшин 2008 оноос аажмаар өсөх хандлагатай байгаа бөгөөд 2011 онд 1000 хүнд ногдох нас баралт 7.2-д хүрсэн нь улсын дүнгээс 0.3 промилоор илүү байна. Харин Төв аймагт 1000 хүнд ногдох нас баралт 8.0 байгаа нь бүсийн дүнгээс 0.9, улсын дүнгээс 1.2 промилоор их байна. Бүсдээ нас баралтын түвшингээр Сэлэнгэ аймаг хамгийн бага буюу 6.7 байна. Нэг нас хүрээгүй нялхасын эндэгдэлийн түвшин бүсэд 10.1, Төв аймагт 11.4 болж өмнөх оноос 3.4 – 0.6 пунктээр буурав.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт Төв аймгийн хэмжээнд 70.28 хүрснээр бүстээ 3-т орж байгаа ба улсын дунджаас 1.96-аар их байна.

2011 онд төвийн бүсийн аймгуудад нийт 1684 хос гэрлэлтээ бүртгүүлж, 483 хос гэрлэлтээ цуцлуулж 243 хүүхэд үрчлэгджээ.

Ажиллах хүч

“Ажиллах хүчний судалгаа”-ы дүнг тархаасан тооцоогоор 2011 онд бүсийн эдийн засгийн идэвхитэй хүн ам 214.1 мянга байгаагаас 199.5 мянга нь 93.18% нь ажиллагчид үлдсэн 6.82% нь ажилгүйчүүд байна. Төв аймагт 45.3 мянган ажиллагчид, 2.6 мянган ажилгүй иргэд байна. Ажиллагчдийн тоогоор Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд тэргүүлж байгаа бол ажилгүйдлийн түвшин Өмнөговь, Дундговь, Дархан-Уул аймгуудад өндөр байна. Бүсийн дүнгээр ажилгүйдлийн түвшин 6.8, бүртгэлтэй ажилгүйчүүд 6372 болов.

Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйн (ХАА) салбар 2011 онд бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 38.6 хувийг үйлдвэрлэв. Малын 2011 оны тооллогын дүнгээр

төвийн бүс улсын нийт малын 23.2 хувь буюу 8449.0 мянган мал тоолуулав. Өмнөх онуудтай харьцуулахад 2008 оноос 12.2 хувь, 2009 оноос 19.7 хувиар буурч, 2010 оныхоос 11.8 хувиар өсөв. Төв аймаг малын тоогоор улсдаа гуравдугаарт, бүсдээ нэгдүгээрт орж байгаа ба нийт 2962 мянган толгой мал тоолуулав.

Төвийн бүсийн малыг өмнөх онтой харьцуулбал тэмээ 5.3 хувь, адуу 11.8 хувь, үхэр 7.7 хувь, хонь 8.38 хувь, ямаа 16.1 хувь тус тус өслөө.

Улсын хэмжээгээр 2011 онд 345.9 мянган га-д, төвийн бүсэд 249.8 мянган га-д тариалалт хийв. Хураасан ургац ургамлын төрлөөр үр тариа 343.5 мянган тонн, төмс 136.7 мянган тонн, хүнсний ногоо 61.7 мянган тонн, тэжээлийн ургамал 19.0 мянган тонн, жимс жимсгэнэ 365 тоннд хүрэв. Нэг га талбайгаас хураасан бүсийн дундаж ургац улсын дунджаас үр тариа 0.5 центнер, төмс 14.9 центнерээр тус тус өндөр байлаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүн, Төсөв

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2011 онд оны үнээр бүсийн дүнгээр 1154.5 тэрбум болж 2008 оноос 59.2 хувь, 2009 оноос 56.8 хувь, 2010 оноос 27.8 хувиар тус тус өсөв. Бүсийн дүнд Өмнөговь 27.2 хувь, Сэлэнгэ 22.1 хувь, Дархан-Уул 17.4 хувь, Төв 16.8 хувь, Дорноговь 8.7 хувь, Дундговь 5.5 хувь, Говьсүмбэр 2.3 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Бүсийн ДНБ-ий 38.9 хувийг ХАА, 38.6 хувийг Аж үйлдвэр, Барилга, 22.4 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлжээ. Үүнийг улсын дүнтэй харьцуулбал ХАА-н салбар 25.9 пунктээр, Аж үйлдвэр, Барилгын салбар 3.6 пунктээр тус тус их, Үйлчилгээний салбар 29.6 пунктээр бага байна.

Нэг хүнд ногдох ДНБ /үйлдвэрлэлийн аргаар тооцсон/ 2011 онд оны үнээр бүсийн дундаж 2545.9 мянган төгрөгт хүрлээ. Улсын дунджаас бүсийн дундаж 1433.4 мянган төгрөгөөр бага, Төв аймгийн дундаж бүсээс 278.0, улсаас 1989.4 мянгаар тус тус доогуур байна.

Орон нутгийн бүсийн орлого 2011 онд урьдчилсан гүйцэтгэлээр бүсэд 164.2 тэрбум, зарлага 154.5 тэрбумд хүрэв. Өмнөх онтой харьцуулахад орлого 92.81 хувь, зарлага 85.31 хувь, 2005 онтой харьцуулахад орлого 12.7 дахин, зарлага 12.5 дахин өсөв. Бүсийн нийт орлогын 66.4 хувийг Өмнөговь, 1.8 хувийг Говьсүмбэр бүрдүүлж, зарлагын 66.6 хувийг Өмнөговь, 2.02 хувийг Говьсүмбэр аймаг зарцуулав. Төв аймаг орлогын 6.08 хувийг, зарлагын 6.06 хувийг эзлэв. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэгийн 8.7 хувь буюу 2570.9 сая төгрөг төвийн бүсэд ногдож, төвийн бүсийн аймгууд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 67281.8 сая төгрөг төвлөрүүлэв. 2009 оноос Төв аймаг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй ба мөн оноос улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймгуудийн тоонд багтсан. 2011 онд 500 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь 2010 оныхоос 335.3 сая төгрөгөөр өсч, 2009 оныхоос 114.1 сая төгрөгөөр буурав.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, Барилга

Аж үйлдвэрийн салбарын бүсийн нийт үйлдвэрлэл оны үнээр 2011 онд 1033785.0 саяд хүрч өмнөх оноос 44.6 хувиар өслөө. Борлуулалтаараа бүстээ Өмнөговь, Сэлэнгэ аймгууд тэргүүлж, Дархан-Уул, Төв аймгууд удаалав. Төвийн бүсийн борлуулалт улсын нийт борлуулалтын 18.4 хувийг эзэлж байна.

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2008 оныхоос 44.2 хувь, 2009 оныхоос 46.8 хувь, 2010 оныхоос 25.7 хувь тус тус өсч 2011 онд 31168.9 сая төгрөг болов. Бүсийн барилгын ажлын 34.5 хувийг Дархан-Уул, 26.8 хувийг Төв аймаг, 12.4 хувийг Дорноговь, 11.9 хувийг Өмнөговь аймаг, 7.7 хувийг Дундговь аймаг, 5 хувийг Сэлэнгэ аймаг, 1.6 хувийг Говьсүмбэр аймаг тус тус гүйцэтгэв.

Боловсрол, Соёл урлаг, Сүм хийд

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр Монгол улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын 98.3 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байна.

2010/2011 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол(СӨБ)-ын байгууллага бүсийн хэмжээнд 179 үйл ажиллагаа явуулж, 29.7 мянган хүүхэд хамрагдсан нь 2009/2010 оны хичээлийн жилээс 3.7 мянга, 2010/2011 оны хичээлийн жилээс 1.5 мянгаар өсчээ. Бүсийн хэмжээнд СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоогоор 2011 онд Сэлэнгэ /7.1 мянга/, Төв /5.8 мянга/, Дархан-Уул /5.0мянга/ аймгууд тэргүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) тоо 2011/2012 оны хичээлийн жилд 156 болж өмнөх оноос нэгээр нэмэгдсэн байна. Үүнд Говьсүмбэр, Өмнөговь аймгуудад тус бүр нэг сургууль нэмэгдсэн бол Төв аймагт нэг сургууль хасагдаж 31 ЕБС-тай болсон байна.

2011/2012 оны хичээлийн жилийн эхэнд ЕБС-д өдрөөр суралцагчдын тоо 83.1 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 1.6 мянгаар буурсан. Бүсийн нийт суралцагчдын хамгийн их буюу 22.26 хувь нь Төв аймагт, Дархан-Уулд 22.02%, Дорноговьд 13.12%, Өмнөговьд 12.64%, Дундговьд 9.87%, Говьсүмбэрт 3.49% нь суралцсан. ЕБС-ийн багш нарын тоо 2011/2012 оны хичээлийн жилд 4484 болж 2010/2011 оны хичээлийн жилээс 0.18 хувиар буурсан дүнтэй байна. Нэг багшид ногдох суралцагчдын тоо бүсэд 18.5 болж улсын дунджаас 0.6 хүүхдээр доогуур байлаа. Харин Төв аймагт нэг багшид 17.5 хүүхэд ногдож бүсийн дунджаас 1, улсын дунджаас 1.6 хүүхдээр бага байна. Энэ үзүүлэлт 2005/2006 оны хичээлийн жилээс аажмаар буурсаар байгаа ба бүсийн дундаж 2011/2012 оны хичээлийн жилд 2005/2006 оны хичээлийн жилээс 6.9 хүүхдээр буурав.

Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолтын тоо 2011 онд 995, үзэгчдийн тоо 462.6 мянган хүн болж 2010 оноос 0.71хувь, 11.23 хувиар тус тус өссөн байна. Бүсийн нийт 2011 оны тоглолтын 37.1 хувь буюу 369 тоглолтыг Сэлэнгэ аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага тоглосон бол Төв аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага 7.4 хувийг тогложээ.

Музейн үзмэрийн тоо бүсийн дүнгээр 2008 онд 26423, 2009 онд 26717, 2010 онд 27856 байсан бол 2011 онд 29644 болж өссөн. 2011 онд сан хөмрөгөө хамгийн олон үзмэрээр баяжуулсан аймаг Дорноговь 1064 үзмэр нэмсэн бол Төв аймаг 518 үзмэр нэмж нийтдээ 8215 үзмэртэй болжээ. Музей үзэгчдийн тоо 2011 онд бүсийн хэмжээнд 67.6 мянга хүрлээ.

2011 онд төвийн бүсийн аймгуудад сүм хийдийн тоо 53, тэнд ажиллагчдийн тоо 350 байна. Дархан-Уул аймагт нийт сүм хийдийн 39.6 хувь буюу 21 сүм хийд үйл ажиллагаа явуулсан бол бүсийн сүм хийдэд ажиллагсдын 31.4 хувь буюу 110 хүн Дундговь аймагт ажилласан байна.

Хүн амын эрүүл мэнд, Гэмт хэрэг

Эрүүл мэндийн салбарт 2011 онд бүсийн хэмжээнд их эмч 989 хүн ажиллаж 2008 оныхоос 0.8 хувиар буурсан бол 2009 оныхоос 1.05 хувь, 2010 оныхоос 1.03 хувиар өссөн. 989 их эмчийн 242 нь Дархан-Уул, 179 нь Дорноговь, 166 нь Сэлэнгэ, 154 нь Төв, 119 нь Өмнөговь, 84 нь Дундговь, 45 нь Говьсүмбэр аймагт тус тус ажилласан байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 450 болж, өмнөх оноос 16 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 329 болж 4 хүнээр буурчээ. Нэг их эмчид ногдох хүний тоо Сэлэнгэ аймагт хамгийн их буюу 583 байхад, хамгийн бага Говьсүмбэр аймагт 299 хүн байна. Төв аймагт нэг их эмчид 547 хүн ногдож

байгаа нь улсын дунджаас 210 хүнээр их байна.Нэг сувилагчид ногдох хүний тоо бүсэд 329 байгаа нь улсын дунджаас 45 хүнээр их байна.

2011 онд Төвийн бүсийн эмнэлэгүүдэд нийт 98.7 мянган хүн хэвтэж эмчлүүлсэнээс 15.6 мянга буюу 16.58 хувь нь төв аймагт хэвтэн эмчлүүлжээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо бүсийн хэмжээнд 2009 онд 4691, 2010 онд 4971 байсан бол 2011 онд 6589 болж 2009 оноос 28.8хувиар, 2010 оноос 24.6 хувиар өссөн байна. Төвийн бүс халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо улсын нийт өвчлөгсдийн 15.4 хувийг эзэлж байгаа бол Төв аймагт төвийн бүсийн 14.7 хувь бүртгэгдсэн. Энэ нь өмнөх оноос 0.9 пунктээр өссөн дүн юм. Үр хөндөлт 2010 онд бүсэд 1359 болж 2009 оноос 722-оор буурсан дүнтэй байсан бол 2011 онд 1366 болж 6-аар өссөн. Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд 2011 онд 2010 оноос үр хөндөлтийг 65.2-15.5 хувиар бууруулсан бол Төв аймагт 26.2 хувиар өсч 106 болсон нь бүсийн дүнгийн 7.76 хувийг эзэллээ. Бүсийн хэмжээнд төрөхийн улмаас 2 эх эндсэнээр хамгийн цөөн эх эндсэн бүсийн нэг болов.Төв аймагт 2005-2008 онд төрөхийн улмаас эх эндээгүй боловч 2009 онд 2 эх эндэж 2010, 2011 онуудад эндэгдэл гараагүй.

Бүсийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 3040 болж 2008 оноос 661 хэргээр, 2009 оноос 418 хэргээр, 2010 оноос 194 хэргээр тус тус буурав. Бүсэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоогоор Төв аймаг нэгдүгээрт орсон ба бүртгэгдсэн гэмт хэргийн хувийг 2005, 2010 онтой харьцуулбал 5.83- 2.74 пунктээр өсчээ.

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо1650 болж бүсүүдээс нэгдүгээрт, нийслийн дараа бичигдэв. Ял шийтгүүлсэн нийт хүний 25.0 хувь нь Дархан-Уул, 24.7 хувь нь Сэлэнгэ, 17.6 хувь нь Төв, 14.2 хувь нь Дорноговь, 10.4 хувь нь Өмнөговь, 5.0 хувь нь Дундговьд, 2.9 хувь нь Говьсүмбэр аймагт шийтгүүлжээ.

**Улсын хэмжээний нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн
зэрэгцүүлэлтэнд эзлэх зиндаа**

	Сум дүүргийн (тоогоор)					Баг хорооны (тоогоор)					Нутаг дэвсгэрийн хэмжээ (мян.кв.км)				
	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Говьсүмбэр Govisumber	21	20	20	21	21	22	21	21	22	21	19	19	19	19	19
Дархан Darkhan-Uul	20	19	19	20	20	20	19	19	20	19	21	21	21	21	20
Дорноговь Dornogovi	16	15	16	15	15	17	16	17	17	16	5	5	5	5	5
Дундговь Dundgovi	13	12	13	13	13	15	14	12	15	13	11	11	11	11	11
Өмнөговь Omnogovi	14	13	14	14	14	14	18	17	15	18	17	1	1	1	1
Сэлэнгэ Selenge	9	10	10	10	10	19	18	18	19	18	18	18	18	18	18
Төв Tov	1	1	1	1	1	7	6	6	7	6	12	12	12	12	12
Улсын дүн *	340	338	338	338	338	1670	1682	1568	1568	1576	1564.1	1564.1	1564.9	1564.9	1564.1

	Хүн амын нягтшил (1 км-т ногдох хүн)					Хүн амын тоо (мян-хүн)					Малын тоогоор (сая-тол)				
	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011
A	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30
Говьсүмбэр Govisumber	4	4	4	4	4	21	21	21	22	22	21	21	21	22	21
Дархан Darkhan-Uul	3	2	2	3	3	7	7	6	6	5	19	19	19	20	20
Дорноговь Dornogovi	21	19	20	20	19	18	17	17	17	17	18	18	18	17	17
Дундговь Dundgovi	19	17	18	18	20	19	19	20	21	21	9	12	12	16	13
Өмнөговь Omnogovi	23	21	21	22	21	20	20	19	20	16	15	13	14	18	16
Сэлэнгэ Selenge	4	3	3	5	5	4	3	3	4	4	17	17	15	13	15
Төв Tov	11	10	10	11	9	8	9	8	8	8	8	5	4	2	3
Улсын дүн *	1.66	1.72	1.75	1.75	1.75	2635.2	2683.5	2735.8	2780.8	2811.6	40.3	43.3	44.0	32.7	36.3

	Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны- үнээр) (тэрбум ₮)					Барилга угсралт, их засварын ажил (тэрбум -₮)					Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт (тэрбум-төг)				
	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011
A	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45
Говьсүмбэр Govisumber	21	21	21	22	22	x	21	19	16	22	6	6	6	8	7
Дархан Darkhan-Uul	10	10	7	7	6	4	6	5	9	6	5	5	5	5	5
Дорноговь Dornogovi	20	20	20	19	18	17	20	20	22	13	9	14	20	21	20
Дундговь Dundgovi	17	17	19	21	20	18	18	16	14	19	17	21	21	20	19
Өмнөговь Omnogovi	5	9	4	4	3	14	15	14	17	15	4	3	2	3	3
Сэлэнгэ Selenge	9	2	2	3	4	20	17	21	21	21	3	2	4	4	4
Төв Tov	8	6	3	5	7	8	9	7	7	8	8	9	7	9	8
Улсын дүн *	4956.6	6555.6	6590.6	8414.5	11087.8	364.4	479.6	250.6	326.5	657.2	2625.2	2928.3	3099.8	4468.2	5626.7

	Хураасан ургац (мян-тн)														
	үр тариа бүгд					төмс бүгд					хүнсний ногоо				
	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011	2007	2008	2009	2010	2011
A	46	47	48	49	50	51	52	53	54	55	56	57	58	59	60
Говьсүмбэр Govisumber	x	x	x	x	x	21	21	21	22	22	21	21	21	21	21
Дархан Darkhan-Uul	6	6	6	5	5	8	4	3	3	3	2	4	3	3	2
Дорноговь Dornogovi	x	x	x	x	x	20	20	20	21	20	18	19	19	20	20
Дундговь Dundgovi	x	x	x	x	x	19	19	18	20	21	20	20	20	22	22
Өмнөговь Omnogovi	x	x	x	x	x	17	17	17	18	18	15	16	17	18	18
Сэлэнгэ Selenge	1	1	1	1	1	1	1	1	2	2	1	1	1	1	1
Төв Tov	2	3	2	2	2	2	2	2	1	1	4	3	2	2	3
Улсын дүн *	114.8	212.9	391.7	355.1	446.1	114.4	134.8	151.2	167.9	201.6	76.4	78.6	78.0	82.3	99.0

Засаг захиргааны нэгж. 2011 оны байдлаар.
ADMINISTRATIVE UNITS

	Сум дүүр- ийн тоо Number of soums and districts	Баг хороо- ны тоо Number of bags and khoroots	Нутаг дэвс- гэрийн хэмжээ мян.кв.км Territory thous kb.km	Хүн амын нягтшил Population density
A	1	2	3	4
Төвийн бүсийн дүн (total)	95	371	473.6	0.96
- Говьсүмбэр Govisumber	3	10	5.5	2.52
- Дархан Darkhan-Uul	4	26	3.3	29.1
- Дорноговь Dornogovi	14	60	109.5	0.55
- Дундговь Dundgovi	15	66	74.7	0.51
- Өмнөговь Omnogovi	15	56	165.4	0.38
- Сэлэнгэ Selenge	17	56	41.2	2.41
- Төв Tov	27	97	74.0	1.16
Баруун бүс Western region	91	466	415.3	0.98
Хангайн бүс Khangai region	99	529	384.3	1.36
Зүүн бүс Eastern region	44	212	286.2	0.66
Нийслэл Capital city	9	152	4.7	253.85
Улсын дүн Total	338	1730	1564.1	1.8

Аймгуудын Дотоодын нийт бүтээгдэхүүний хувь хэмжээ,оны үнээр
PROVINCIAL GROSS DOMESTIC PRODUCT, by regions, aimags and the, at current prices

	Бүрд , Total						(тэр бүм-т, mln. tog) 2011 оны дүнд эзлэх хувь		
	2006	2007	2008	2009	2010	2011	ү ү н э э с		
							X.A.A Agricul- ture	A.Y.Барилга Industry,con struction	Үйлчилгээ Services
A	1	2	3	4	5	6	7	8	9
Төвийн бүсийн ДНБ	369.0	468.1	725.1	736.1	903.5	1154.4	38.9	38.6	22.4
- Говьсүмбэр Govisumber	11.5	8.3	19.5	18.5	29.6	26.5	14.1	36.1	49.8
- Дархан Darkhan-Uul	59.7	82.7	135.4	127.4	184.6	201.3	13.1	58.3	28.5
- Дорноговь Dornogovi	22.0	27.8	53.3	55.1	61.1	99.9	43.7	4.9	51.4
- Дундговь Dundgovi	39.5	42.7	58.9	53.2	54.2	63.9	63.0	3.6	33.4
- Өмнөговь Omnogovi	60.6	83.0	110.4	141.7	222.6	313.8	13.2	77.2	9.6
- Сэлэнгэ Selenge	101.4	132.4	208.3	189.2	193.9	255.0	61.3	22.9	15.8
- Төв Tov	74.3	91.2	139.3	151.0	157.5	194.0	76.7	2.9	20.4
Баруун бүс Western region	271.4	342.5	480.6	377.1	381.9	479.5	53.3	5.2	41.4
Хангайн бүс Khangai region	988.5	1338.8	1475.0	1299.0	1608.6	1883.4	27.3	57.8	14.9
Зүүн бүс Eastern region	225.3	271.5	279.9	264.5	294.6	376.8	48.3	26.1	25.6
Нийслэл Capital city	2173.4	2535.8	3595.0	3913.9	5225.9	7193.6	0.4	30.7	68.8
Улсын дүн Total	4027.6	4956.7	6555.6	6590.6	8414.5	11087.7	13.0	35.0	52.0

Нэг хүнд ногдох ДНБ, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр
GDP per person, by regions, aimags and the Capital, at current prices

(мян.төг-thous.tugrug)											
	Нэг хүнд ногдох ДНБ						2011% 2006	2011% 2010	Аймгууд бүсийн дүнд харьцсан зөрүү		
	2006	2007	2008	2009	2010	2011			2006	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Төвийн бүсийн дүн	855.3	1084.7	1671.8	1675.7	2022.2	2545.9	297.66	125.90	х	х	х
- Говьсүмбэр	958.3	687.5	1575.8	1454.3	2257	1951.9	203.68	86.48	103.0	234.8	-594.0
- Дархан	667.0	921.7	1498.8	1387.4	1965.7	2108.9	316.18	107.28	-188.3	-56.5	-437.0
- Дорноговь	411.1	508.2	953.5	963.3	1048.6	1677.4	408.03	159.97	-444.2	-973.6	-868.5
- Дундговь	879.4	974.5	1380.7	1283.8	1363.4	1670.8	189.99	122.55	24.1	-658.8	-875.1
- Өмнөговь	1152.8	1539.4	1990.0	2457.3	3693.1	5020.4	435.50	135.94	297.5	1670.9	2474.5
- Сэлэнгэ	1069.1	1402.2	2208.2	1991.6	2004.8	2587.2	242.00	129.05	213.8	-17.4	41.3
- Төв	883.8	1100.0	1685.7	1809.5	1858.7	2267.9	256.61	122.02	28.5	-163.5	-278.0
Баруун бүс	708.7	901.5	1284.3	1024.9	1057.3	1344.4	189.70	127.15	х	х	х
Хангайн бүс	1879.6	2556.1	2819.8	2481.2	3077.5	3602.9	191.68	117.07	х	х	х
Зүүн бүс	1172.0	1425.0	1481.1	1406.0	1572.5	2007.6	171.30	127.67	х	х	х
Нийслэл	2100.5	2356.4	3200.6	3338.8	4281.4	5683.1	270.56	132.74	х	х	х
Улсын дүн	1568.9	1905.0	2480.2	2449.0	3072.5	3979.3	253.64	129.51	х	х	х

Суурин хүн амын тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
RESIDENT POPULATION, by regions, aimags and at the end of the year

(мян-хүн thous.persons)

	Суурин хүн амын тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн дүн	436.1	436.5	437.9	435.7	442.9	450.7	456.1	104.6	101.20	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	12.2	12.3	12.6	12.5	12.9	13.3	13.9	113.9	104.5	2.80	3.0	3.0
- Дархан	87.7	87.5	87.6	90.8	92.9	94.9	96.0	109.5	101.2	20.11	21.1	21.0
- Дорноговь	53.3	54.5	55.6	56.7	57.7	58.9	60.2	112.9	102.2	12.22	13.1	13.2
- Дундговь	49.6	49.2	48.8	42.0	40.8	38.7	37.7	76.0	97.4	11.37	8.6	8.3
- Өмнөговь	46.1	46.5	46.9	56.4	58.9	61.6	63.4	137.5	102.9	10.57	13.7	13.9
- Сэлэнгэ	99.8	100.1	100.5	94.5	95.6	97.9	99.2	99.4	101.3	22.88	21.7	21.7
- Төв	87.4	86.4	85.9	82.8	84.1	85.4	85.7	98.1	100.4	20.04	18.9	18.8
Баруун бүс	409.0	410.0	411.1	370.7	365.2	357.1	356.2	87.1	99.7	x	x	x
Хангайн бүс	551.8	553.8	555.7	523.5	523.6	521.7	523.7	94.9	100.4	x	x	x
Зүүн бүс	200.2	200.2	199.3	188.5	187.7	186.9	188.4	94.1	100.8	x	x	x
Нийслэл	965.3	994.3	1031.2	1147.7	1196.8	1244.4	1287.1	133.3	103.4	x	x	x
Улсын дүн	2562.4	2594.8	2635.2	2666.1	2716.2	2760.8	2811.5	109.7	101.8	x	x	x

Өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
NUMBER OF HOUSEHOLDS, by regions, aimags and at the end of the year

(мян-хүн thous.household)

	Өрхийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн дүн	105.8	110.4	113.7	116.9	123.5	131.3	137.1	129.6	104.4	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	3.1	3.2	3.4	3.8	3.8	4.1	4.5	145.2	109.8	2.9	3.1	3.28
- Дархан	19.6	22.3	22.6	23.1	25.0	27.2	28.0	142.9	102.9	18.5	20.7	20.42
- Дорноговь	13.3	14.0	14.8	15.3	16.1	17.2	18.4	138.3	107.0	12.6	13.1	13.42
- Дундговь	12.5	12.6	12.7	12.7	13.0	13.2	13.2	105.6	100.0	11.8	10.1	9.63
- Өмнөговь	12.5	12.8	12.7	13.2	14.3	15.3	17.1	136.8	111.8	11.8	11.7	12.47
- Сэлэнгэ	22.4	22.2	23.5	24.1	26.2	28.2	29.0	129.5	102.8	21.2	21.5	21.15
- Төв	22.4	23.3	24.0	24.7	25.1	26.1	26.9	120.1	103.1	21.2	19.9	19.62
Баруун бүс	95.9	95.9	97.3	96.4	97.0	97.7	96.8	100.9	99.1	x	x	x
Хангайн бүс	140.4	139.7	143.9	146.0	151.0	156.9	160.1	114.0	102.0	x	x	x
Зүүн бүс	48.7	49.3	50.7	51.7	54.5	57.4	59.1	121.4	103.0	x	x	x
Нийслэл	205.5	215.7	226.9	234.7	251.8	273.2	306.8	149.3	112.3	x	x	x
Улсын дүн	596.3	611.0	632.5	645.7	677.8	716.5	759.9	127.4	106.1	x	x	x

Бүтэн өнчин хүүхдийн тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
DOUBLE ORPHAN CHILDREN, by regions, aimags and the capital,
at the end of year

	Бүтэн өнчин хүүхдийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн дүн	944	911	882	801	755	696	641	67.9	92.1	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	22	13	19	19	15	17	14	63.6	82.4	2.3	2.4	2.2
- Дархан	250	249	273	256	259	195	166	66.4	85.1	26.5	28.0	25.9
- Дорноговь	89	87	54	54	59	51	62	69.7	121.6	9.4	7.3	9.7
- Дундговь	57	55	49	44	39	58	58	101.8	100.0	6.0	8.3	9.0
- Өмнөговь	91	66	61	51	52	49	51	56.0	104.1	9.6	7.0	8.0
- Сэлэнгэ	250	272	274	234	190	183	163	65.2	89.1	26.5	26.3	25.4
- Төв	185	169	152	143	141	143	127	68.6	88.8	19.6	20.5	19.8
Баруун бүс	1071	939	853	871	869	853	763	71.2	89.4	x	x	x
Хангайн бүс	1303	1289	1186	1220	1101	1045	913	70.1	87.4	x	x	x
Зүүн бүс	399	399	474	397	350	331	326	81.7	98.5	x	x	x
Нийслэл	1732	1738	1679	1729	1608	1741	1662	96.0	95.5	x	x	x
Улсын дүнд	5449	5276	5074	5018	4683	4666	4305	79.0	92.3	x	x	x

Хагас өнчин хүүхдийн тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
ORPHAN CHILDREN, by regions, aimags and the capital, at the end of year

	Хагас өнчин хүүхдийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	7936	7711	7288	6884	6804	5969	5804	73.1	97.2	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	168	154	178	150	171	155	176	104.8	113.5	2.1	2.6	3.0
- Дархан	1587	1685	1560	1557	1479	1138	1200	75.6	105.4	20.0	19.1	20.7
- Дорноговь	875	887	834	772	777	736	725	82.9	98.5	11.0	12.3	12.5
- Дундговь	761	732	652	582	589	581	603	79.2	103.8	9.6	9.7	10.4
- Өмнөговь	847	820	840	761	698	614	531	62.7	86.5	10.7	10.3	9.1
- Сэлэнгэ	1994	1772	1700	1635	1779	1490	1506	75.5	101.1	25.1	25.0	25.9
- Төв	1704	1661	1524	1427	1311	1255	1063	62.4	84.7	21.5	21.0	18.3
Баруун бүс	11146	10095	9495	9704	9453	8288	7975	71.6	96.2	x	x	x
Хангайн бүс	12416	12306	11577	10802	10190	9777	9277	74.7	94.9	x	x	x
Зүүн бүс	3961	3917	3919	3544	3235	2921	2725	68.8	93.3	x	x	x
Нийслэл	11629	11697	12409	12154	11492	11293	10684	91.9	94.6	x	x	x
Улсын дүнд	47088	45726	44688	43088	41174	38248	36465	77.4	95.3	x	x	x

16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо
бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
HOUSEHOLDS WITH 4 AND MORE CHILDREN AGED BELOW 16,
by regions, aimags and the Capital, at the end of year

	16 хүртэлх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрх							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	5586	5542	4687	3445	3066	2516	2607	46.7	103.6	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	112	67	87	61	52	101	64	57.1	63.4	2.0	4.0	2.5
- Дархан	640	963	833	613	133	238	242	37.8	101.7	11.5	9.5	9.3
- Дорноговь	712	606	477	427	370	274	234	32.9	85.4	12.7	10.9	9.0
- Дундговь	699	575	538	309	387	329	264	37.8	80.2	12.5	13.1	10.1
- Өмнөговь	928	925	705	490	485	432	254	27.4	58.8	16.6	17.2	9.7
- Сэлэнгэ	1300	1312	1302	743	1096	486	875	67.3	180.0	23.3	19.3	33.6
- Төв	1195	1094	745	802	543	656	674	56.4	102.7	21.4	26.1	25.9
Баруун бүс	14417	14514	13300	10429	8775	8347	7616	52.8	91.2	x	x	x
Хангайн бүс	11259	9908	8155	7525	6328	5285	5589	49.6	105.8	x	x	x
Зүүн бүс	2598	2182	3335	2463	1552	1604	1307	50.3	81.5	x	x	x
Нийслэл	8575	7873	8448	7988	7272	6394	6959	81.2	108.8	x	x	x
Улсын дүн	42435	40019	37925	31850	26993	24146	24078	56.7	99.7	x	x	x

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
FEMALE-HEADED HOUSEHOLDS, by regions, aimags and the Capital, at the end of year

	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	13273	13453	13777	15113	15867	16489	17226	129.8	104.5	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	592	567	581	647	678	569	652	110.1	114.6	4.5	3.5	3.8
- Дархан	3021	3005	2988	3373	3793	4256	4136	136.9	97.2	22.8	25.8	24.0
- Дорноговь	1667	1892	2180	2190	2415	2377	2413	144.8	101.5	12.6	14.4	14.0
- Дундговь	1486	1560	1598	1527	1649	1820	1888	127.1	103.7	11.2	11.0	11.0
- Өмнөговь	1906	1933	1812	2145	2205	2380	2665	139.8	112.0	14.4	14.4	15.5
- Сэлэнгэ	1965	2034	2124	2585	2793	2364	2709	137.9	114.6	14.8	14.3	15.7
- Төв	2636	2462	2494	2646	2334	2723	2763	104.8	101.5	19.9	16.5	16.0
Баруун бүс	10647	10362	10615	11095	12060	11947	11795	110.8	98.7	x	x	x
Хангайн бүс	17837	17846	17445	18108	19011	19381	19358	108.5	99.9	x	x	x
Зүүн бүс	6549	6462	6968	7086	7544	7639	8639	131.9	113.1	x	x	x
Нийслэл	22022	24096	23323	25391	26727	25557	24368	110.7	95.3	x	x	x
Улсын дүн	70328	72219	72128	76793	81209	81013	81386	115.7	100.5	x	x	x

**16 хүртлэх насны хүүхэдтэй, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо
бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
SINGLE WOMAN, with children aged below 16
by regions, aimags and the Capital, at the end of year**

	Хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	2	3	4	5	6	7	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн Дүн	9469	8749	8897	9573	8930	8058	7890	83.3	97.92	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	444	392	398	301	324	327	254	57.2	77.68	4.69	4.06	3.22
- Дархан	1854	1704	1770	2102	1679	1766	1605	86.6	90.88	19.58	21.92	20.34
- Дорноговь	1370	1292	1311	1666	1664	1146	1138	83.1	99.30	14.47	14.22	14.42
- Дундговь	1065	1068	998	1008	900	862	906	85.1	105.10	11.25	10.70	11.48
- Өмнөговь	1496	1424	1389	1300	1267	1173	1286	86.0	109.63	15.80	14.56	16.30
- Сэлэнгэ	1701	1616	1744	1848	1910	1540	1527	89.8	99.16	17.96	19.11	19.35
- Төв	1539	1253	1287	1348	1186	1244	1174	76.3	94.37	16.25	15.44	14.88
Баруун бүс	5256	4963	4659	4588	4835	4112	3954	75.2	96.16	x	x	x
Хангайн бүс	12181	10887	10466	9536	9780	9233	9178	75.3	99.40	x	x	x
Зүүн бүс	4632	4154	4001	4058	3781	3993	3693	79.7	92.49	x	x	x
Нийслэл	16877	17445	15494	14719	15001	14541	13994	82.9	96.24	x	x	x
Улсын дүн	48415	46198	43517	42474	42327	39937	38709	80.0	96.93	x	x	x

**Төрсөн эхчүүдийн тоо, бүс, нийслэлээр
WOMEN WHO GAVE BIRTH, by regions, aimags and the Capital**

	Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн Дүн	7530	7852	9170	9992	11495	10170	11038	146.6	108.53	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	231	273	288	330	381	346	387	167.5	111.85	3.07	3.40	3.51
- Дархан	1466	1539	1904	1947	2387	2049	2291	156.3	111.81	19.47	20.15	20.76
- Дорноговь	999	1109	1247	1276	1435	1338	1523	152.5	113.83	13.27	13.16	13.80
- Дундговь	904	904	1021	1107	1245	970	906	100.2	93.40	12.01	9.54	8.21
- Өмнөговь	826	806	935	1224	1357	1154	1256	152.1	108.84	10.97	11.35	11.38
- Сэлэнгэ	1703	1709	2033	2165	2537	2329	2504	147.0	107.51	22.62	22.90	22.69
- Төв	1401	1512	1742	1943	2153	1984	2171	155.0	109.43	18.61	19.51	19.67
Баруун бүс	8750	9043	9182	10370	10487	8954	9575	109.4	106.94	x	x	x
Хангайн бүс	9972	10184	11266	13141	14025	12589	13748	137.9	109.21	x	x	x
Зүүн бүс	3497	3814	4180	4664	4996	4536	4842	138.5	106.75	x	x	x
Нийслэл	15397	17987	22613	25284	27732	26693	29952	194.5	112.21	x	x	x
Улсын дүн	45146	48880	56411	63451	68735	62942	69155	153.2	109.87	x	x	x

**1000 хүнд ногдох хүн амын төрөлт, бүс, аймаг, нийслэлээр
CRUDE BIRTH RATE, by regions, aimags and the Capital**

	1000 хүнд ногдох төрөлт (тоогоор)							2011% 2005	2011% 2010	Аймгууд бүсийн дүнд харьцсан зөрүү +, -		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн Дүн	17.9	17.3	18.0	23.2	26.3	22.9	24.7	137.99	107.86	x	x	x
- Говьсүмбэр	19.1	22.3	23.6	26.9	30.2	26.5	28.6	149.7	107.92	1.2	3.6	3.9
- Дархан	16.7	17.6	21.7	21.6	26.3	21.9	24.1	144.3	110.05	-1.2	-1.0	-0.6
- Дорноговь	19.0	20.6	22.6	22.9	25.1	23.1	25.6	134.7	110.82	1.1	0.2	0.9
- Дундговь	18.2	18.4	20.9	26.1	30.2	24.5	23.8	130.8	97.14	0.3	1.6	-0.9
- Өмнөговь	17.9	17.5	20.1	22.2	23.7	19.2	21.7	121.2	113.02	0.0	-3.7	-3.0
- Сэлэнгэ	17.0	17.1	20.0	23.1	26.8	24.3	25.5	150.0	104.94	-0.9	1.4	0.8
- Төв	16.0	17.5	20.4	23.7	26.0	23.6	25.6	160.0	108.47	-1.9	0.7	0.9
Баруун бүс	21.4	22.2	22.5	28.6	28.6	24.8	26.9	125.7	108.47	x	x	x
Хангайн бүс	18.1	18.5	20.4	27.0	27.0	24.2	26.4	145.9	109.09	x	x	x
Зүүн бүс	17.5	19.1	21.0	26.6	26.6	24.6	26.7	152.6	108.54	x	x	x
Нийслэл	16.3	18.5	22.4	23.8	23.8	22.0	23.9	146.6	108.64	x	x	x
Улсын дүн	91.2	17.8	19.0	24.1	25.7	23.1	25.1	27.52	108.66	x	x	x

1000 хүнд ногдох хүн амын нас баралт, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
CRUDE DEATH RATE, by regions, aimags and the Capital, at the end of year

	1000 хүнд ногдох нас баралт (тоогоор)							2011% 2005	2011% 2010	Аймгууд бүсийн дүнд харьцсан зөрүү +, -		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	6.7	7.0	6.6	6.0	6.5	7.0	7.2	107.46	102.86	x	x	x
- Говьсүмбэр	7.5	5.8	5.8	6.0	6.9	6.4	7.2	96.0	112.50	0.8	-0.6	0.0
- Дархан	7.6	6.9	6.2	6.0	7.0	7.2	7.4	97.4	102.78	0.9	0.2	0.2
- Дорноговь	6.9	5.4	5.7	5.8	5.4	6.5	7.3	105.8	112.3	0.2	-0.5	0.1
- Дундговь	5.3	6.1	5.3	6.1	6.8	7.9	8.0	150.9	101.27	-1.4	0.9	0.8
- Өмнөговь	6.5	4.3	6.0	5.1	5.8	5.6	5.9	90.8	105.36	-0.2	-1.4	-1.3
- Сэлэнгэ	6.6	6.0	5.8	6.2	6.7	7.2	6.7	101.5	93.06	-0.1	0.2	-0.5
- Төв	6.2	6.6	6.2	6.5	7.1	7.6	8.0	129.0	105.26	-0.5	0.6	0.8
Баруун бүс	5.7	5.6	5.3	5.8	7.0	7.0	7.1	124.6	101.43	x	x	x
Хангайн бүс	6.7	6.5	6.2	6.6	6.4	8.0	7.8	116.4	97.50	x	x	x
Зүүн бүс	6.7	6.6	6.4	6.8	7.3	7.4	8.0	119.4	108.11	x	x	x
Нийслэл	6.5	6.3	5.6	5.3	5.4	5.8	6.1	93.8	105.17	x	x	x
Улсын дүн	6.5	6.5	6.2	5.8	6.3	6.7	6.9	106.2	103.0	x	x	x

	Төрсөн хүүхэд Births	Нас барсан хүн Deaths	Цэвэр өсөлт Natural increase	Гэрлэсэн хүн Marriages	Цуцалсан хүний тоо Divorces	Үрчлэгдсэн хүүхэд Adoption	Төрсөн хүүхэд хүйсээр Sex		Төрөх үеийн хүйсийн харьцаа sex ratio
							Эрэгтэй male	Эмэгтэй female	
	1	2	3	4	5	6	7	8	9
Төвийн бүсийн дүн	11188	3254	7934	1684	483	243	5732	5456	105.1
- Говьсүмбэр	389	98	291	49	20	5	201	188	106.9
- Дархан	2302	707	1595	402	153	43	1171	1131	103.5
- Дорноговь	1525	433	1092	244	62	17	761	764	99.6
- Дундговь	909	307	602	117	19	20	448	461	97.2
- Өмнөговь	1359	366	993	136	54	20	715	644	111.0
- Сэлэнгэ	2513	661	1852	446	115	80	1299	1214	107.0
- Төв	2191	682	1509	290	60	58	1137	1054	107.9
Баруун бүс	9611	2527	7084	1953	177	459	4822	4789	100.7
Хангайн бүс	13809	4102	9707	2075	561	551	6964	6845	101.7
Зүүн бүс	5019	1504	3515	879	216	173	2577	2442	105.5
Нийслэл	30226	7768	22458	5278	1785	667	15602	14624	106.7
Улсын дүн	69853	19155	50698	11869	3222	2093	35697	34156	104.5

Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр
LIFE EXPECTANCY AT BIRTH , by aimags and the Capital

	Дундаж наслалт							2011% 2005	2011% 2010	Аймгууд улсын зөрүү +, -	
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2010	2011
	2	3	4	5	6	7	8	8	9	10	11
- Говьсүмбэр	67.39	67.84	68.32	69.01	69.83	69.89	71.06	105.45	101.67	1.84	2.74
- Дархан	63.00	63.60	64.24	64.97	65.65	65.71	66.82	106.06	101.69	-2.34	-1.50
- Дорноговь	64.54	65.16	65.80	66.50	67.25	67.31	68.44	106.04	101.68	-0.74	0.12
- Дундговь	67.81	68.22	68.66	69.41	70.17	70.23	71.41	105.31	101.68	2.18	3.09
- Өмнөговь	66.19	66.58	67.00	67.61	68.47	68.53	69.68	105.27	101.68	0.48	1.36
- Сэлэнгэ	66.12	66.74	67.39	68.18	68.87	68.93	70.09	106.00	101.68	0.88	1.77
- Төв	67.00	67.62	68.26	69.11	69.76	69.83	70.28	104.90	100.64	1.78	1.96
Улсын дүн	65.21	65.85	66.54	67.23	67.96	68.05	68.32	104.77	100.40	x	x

**Эдийн засгийн идэвхитэй хүн ам, бүс, аймаг, нийслэлээр,
ECONOMICALLY ACTIVE POPULATION, by regions, aimags, and the Capital**

(мян-хүн thous.persons)

	Эдийн засгийн идэвхитэй хүн ам							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн Дүн	176.4	180.3	183.2	185.5	215.6	215.4	214.1	121.37	99.40	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	4.3	3.9	4.3	4.3	6.1	5.8	5.6	130.23	96.55	2.44	2.69	2.62
- Дархан	27.2	28.8	29.2	34.5	40.4	39.0	40.2	147.79	103.08	15.42	18.11	18.78
- Дорноговь	19.9	19.7	20.1	20.8	25.3	29.2	21.4	107.54	73.29	11.28	13.56	10.00
- Дундговь	23.4	23.3	23.6	22.7	24.1	24.2	24.4	104.27	100.83	13.27	11.23	11.40
- Өмнөговь	22.1	21.7	22.5	20.6	27.3	27.7	28.9	130.77	104.33	12.53	12.86	13.50
- Сэлэнгэ	36.1	38.5	38.8	39.2	50.1	47.1	45.7	126.59	97.03	20.46	21.87	21.35
- Төв	43.4	44.4	44.7	43.4	42.3	42.4	47.9	110.37	112.97	24.60	19.68	22.37
Баруун бүс	173.8	176.0	170.7	164.4	188.6	187.9	188.2	108.29	100.16	x	x	x
Хангайн бүс	239.5	246.0	249.7	249.4	268.8	268.3	253.4	105.80	94.45	x	x	x
Зүүн бүс	72.4	75.0	75.1	74.0	76.9	80.4	86.2	119.06	107.21	x	x	x
Нийслэл	339.1	365.5	375.3	398.2	388.0	395.1	382.8	112.89	96.89	x	x	x
Улсын дүн	1001.2	1042.8	1054.0	1071.5	1137.9	1147.1	1124.7	112.34	98.05	x	x	x

**Ажиллагчдын тоо, бүс аймаг, нийслэлээр
EMPLOYEES, by region, aimags and the Capital**

(мян-хүн thous.persons)

	Ажиллагчдын тоо							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн Дүн	171.9	175.9	179.3	181.4	191.4	195.4	199.5	116.06	102.10	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	4.2	3.8	4.2	4.2	4.8	5.0	5.3	126.19	106.00	2.44	2.6	2.7
- Дархан	26.4	27.9	28.2	33.3	34.1	34.7	36.8	139.39	106.05	15.36	17.8	18.4
- Дорноговь	19.5	19.5	19.8	20.5	20.1	24.6	20.2	103.59	82.11	11.34	12.6	10.1
- Дундговь	22.6	22.5	23.0	22.2	20.9	21.8	22.3	98.67	102.29	13.15	11.2	11.2
- Өмнөговь	21.6	21.2	22.2	20.1	23.2	23.4	24.5	113.43	104.70	12.57	12.0	12.3
- Сэлэнгэ	34.9	37.4	37.8	38.2	48.8	46.1	45.1	129.23	97.83	20.30	23.6	22.6
- Төв	42.7	43.6	44.1	42.9	39.5	39.8	45.3	106.09	113.82	24.84	20.4	22.7
Баруун бүс	165.3	167.6	164.6	158.5	174.5	169.0	167.8	101.51	99.29	x	x	x
Хангайн бүс	227.6	234.9	238.9	238.5	236.6	236.4	232.3	102.07	98.27	x	x	x
Зүүн бүс	69.8	72.1	72.6	71.4	70.0	72.0	76.7	109.89	106.53	x	x	x
Нийслэл	333.7	359.4	368.7	391.9	333.8	360.9	361.4	108.30	100.14	x	x	x
Улсын дүн	968.3	1009.9	1024.1	1041.7	1006.3	1033.7	1037.7	107.17	100.39	x	x	x

**Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст
REGISTERED UNEMPLOYED, by regions, aimags and the Capital, at the end of year**

	Бүртгэлтэй ажилгүйчүүд бүгд Unemployed - total							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7			10	11	12
Төвийн бүсийн дүн	4514	4369	4161	3972	5379	6868	6372	141.16	92.78	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	129	134	164	113	157	128	477	369.77	372.66	2.86	2.9	1.86
- Дархан	837	881	1066	1159	1641	1773	1907	227.84	107.56	18.54	30.5	25.82
- Дорноговь	415	222	385	322	532	642	656	158.07	102.18	9.19	9.9	9.35
- Дундговь	778	759	589	448	554	848	638	82.01	75.24	17.24	10.3	12.35
- Өмнөговь	494	506	339	492	484	979	705	142.71	72.01	63.50	9.0	14.25
- Сэлэнгэ	1176	1096	1008	978	1120	998	1135	96.51	113.73	26.05	20.8	14.53
- Төв	685	771	610	460	891	1500	854	124.67	56.93	15.18	21.8	13.40
Баруун бүс	8568	8390	5958	5725	7886	7158	6195	72.30	86.55	x	x	x
Хангайн бүс	11907	11135	10660	11109	14463	12400	11293	94.84	91.07	x	x	x
Зүүн бүс	2511	2927	2622	2680	2672	2736	3980	158.50	145.47	x	x	x
Нийслэл	5428	6107	6544	6327	7677	9088	29331	540.36	322.74	x	x	x
Улсын дүн	32928	32928	29945	29813	38077	38250	57171	173.62	149.47	x	x	x

Ажилгүйдлийн түвшин, бүс, аймаг, нийслэлээр
UNEMPLOYMENT RATE, by regions, aimags and the Capital

	Ажилгүйдлийн түвшин							2011% 2005	2011% 2010	Аймгууд бүсийн дундажтай харьцсан зөрүү		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	2.4	2.7	2.6	10.9	11.2	9.3	6.8	283.33	73.12	х	х	х
- Говьсүмбэр	3.0	3.4	3.8	17.2	21.2	14.3	4.8	160.00	33.57	0.60	5.00	-2.00
- Дархан	3.1	3.1	3.6	20.1	15.5	11.0	8.4	270.97	76.36	0.70	4.30	1.70
- Дорноговь	2.1	1.1	1.9	14.5	20.7	15.8	5.5	261.90	34.81	-0.30	9.50	6.50
- Дундговь	3.3	3.3	2.5	9.4	13.3	10.1	8.8	266.67	87.13	0.90	2.10	0.80
- Өмнөговь	2.2	2.3	1.5	12.8	15.0	15.4	15.3	695.45	99.35	-0.20	3.80	6.10
- Сэлэнгэ	3.3	2.8	2.6	3.7	2.5	2.1	1.4	42.42	66.67	0.90	-8.70	-7.20
- Төв	1.6	1.7	1.4	5.4	6.5	6.0	5.5	343.75	91.67	-0.80	-1.30	-2.30
Баруун бүс	4.9	4.8	3.5	7.0	7.5	10.1	10.8	220.41	106.93	х	х	х
Хангайн бүс	5.0	4.5	4.3	8.9	12.0	11.9	8.3	166.00	69.75	х	х	х
Зүүн бүс	3.5	3.9	3.5	4.4	9.0	10.5	11.1	317.14	105.71	х	х	х
Нийслэл	1.6	1.7	1.7	10.9	14.0	8.7	5.6	350.00	64.37	х	х	х
Улсын дүн	3.3	3.2	2.8	9.2	11.6	9.9	7.7	233.33	77.78	х	х	х

Малын тоо,бүс,аймаг,төрлөөр оны эцэст
NUMBER OF LIVESTOCK, by regions,aimags and the,by type, at the end of year

	Бүх малын тоо бүгд - Total мян - тол . thous.heads							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн Дүн	6628.2	7071.2	8400.2	9619.5	10527.0	7557.9	8449.0	127.5	111.8	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	155.8	170.2	188.7	170.9	168.7	153.2	189.7	121.8	123.8	2.35	2.03	2.25
- Дархан	142.9	180.2	230.4	345.3	361.5	249.8	256.8	179.7	102.8	2.16	3.31	3.04
- Дорноговь	971.0	712.4	814.7	932.7	1076.9	1056.8	1207.4	124.3	114.3	14.65	13.98	14.29
- Дундговь	1829.1	1905.1	2109.6	2040.6	2147.1	1111.5	1348.7	73.7	121.3	27.60	14.71	15.96
- Өмнөговь	1121.6	1155.7	1400.0	1684.9	1755.2	1010.3	1223.5	109.1	121.1	16.92	13.37	14.48
- Сэлэнгэ	627.5	774.4	1030.2	1442.1	1553.4	1265.6	1260.9	200.9	99.6	9.47	16.75	14.92
- Төв	1780.3	2173.2	2626.6	3003.0	3464.2	2710.7	2962.0	166.4	109.3	26.86	35.87	35.06
Баруун бүс	9242.1	10915.0	12301.7	12157.5	10888.4	7418.5	8525.4	92.2	114.9	х	х	х
Хангайн бүс	10090.3	11852.6	14030.7	15971.1	16716.2	12216.5	13472.4	133.5	110.3	х	х	х
Зүүн бүс	4191.2	4642.1	5199.7	5155.6	5491.5	5273.8	5610.3	133.9	106.4	х	х	х
Нийслэл	247.0	322.0	331.2	384.8	400.8	262.9	278.9	112.9	106.1	х	х	х
Улсын дүн	30398.8	34802.9	40263.5	43288.5	44023.9	32729.6	36336.0	119.5	111.0	х	х	х

	Тэмээ Camel мян - тол . thous.heads							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Төвийн бүсийн дүн	123.1	120.3	123.2	129.8	136.7	135.0	142.1	115.4	105.3	100.0	100.0	100.0
- Говьсүмбэр	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.6	150.0	120.0	0.32	0.37	0.42
- Дархан	0.1	0.3	0.4	0.5	0.4	0.7	0.5	500.0	71.4	0.08	0.52	0.35
- Дорноговь	28.5	25.5	24.5	25.1	26.1	28.1	30.0	105.3	106.8	23.15	20.81	21.11
- Дундговь	20.7	19.7	19.8	19.9	20.7	18.9	19.7	95.2	104.2	16.82	14.00	13.86
- Өмнөговь	70.8	71.7	75.4	80.8	85.7	83.8	87.8	124.0	104.8	57.51	62.07	61.79
- Сэлэнгэ	0.4	0.5	0.5	0.7	0.7	0.8	0.6	150.0	75.0	0.32	0.59	0.42
- Төв	2.2	2.1	2.1	2.4	2.6	2.2	2.9	131.8	131.8	1.92	1.63	2.04
Баруун бүс	68.3	70.6	73.0	71.3	70.9	64.8	67.6	99.0	104.3	х	х	х
Хангайн бүс	39.5	39.9	42.3	45.2	49.1	49.0	50.2	127.1	102.4	х	х	х
Зүүн бүс	23.2	22.6	21.9	20.0	20.2	20.5	19.9	85.8	97.1	х	х	х
Нийслэл	0.1	0.1	0.1	0.1	0.2	0.2	0.2	200.0	100.0	х	х	х
Улсын дүн	254.2	253.5	260.5	266.4	277.1	269.5	280.0	110.1	103.9	х	х	х

	Адуу Horse мян- тол. thous.heads							2011% 2005	2011% 2010	Бүсийн дүнд аймгуудын эзлэх хувь		
	2005	2006	2007	2008	2009	2010	2011			2005	2010	2011
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
